



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 02


Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1, 36 дугаар зүйл, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/01 тоот тушаалаар батлагдсан "Боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм", ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрэм"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд, биелэлтийг хангаж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиргаа, мониторингийн газрын дарга /Л.Пүрэв/, бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.
3. Энэхүү дүрэм батлагдсантай холбогдуулан ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 04 тоот тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрэм"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.БЭГЗ

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралт



**МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шинжлэх ухаан, технологийн их сургууль /цаашид ШУТИС гэх/ нь үүсгэн байгуулагч буюу төрийн төлөөлөл, багш, оюутан, төгсөгчдийн хамтын удирдлагын төлөөллөөс бүрдсэн Удирдах зөвлөлтэй байна.
- 1.2. Удирдах зөвлөлийн үндсэн зорилго нь ШУТИС-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, их сургуулийг хөгжүүлэх бодлого стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, сургуулийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.
- 1.3. Удирдах зөвлөл нь Монгол Улсын үндсэн хууль, Боловсролын тухай багц хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа баримтална.
- 1.4. Удирдах зөвлөл нь хууль ёсыг сахин дээдлэх, эрх тэгш, хариуцлагатай хамтран ажиллах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх, олон талын оролцоог хангах зарчмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Удирдах зөвлөлийн бүтэц зохион байгуулалт


- 2.1. Удирдах зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүдээс бүрдсэн 15 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.2. ШУТИС-ийг үүсгэн байгуулагч нь Монгол Улсын Засгийн газар буюу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид БАЭТЗТБ гэх/ мөн.
- 2.3. Үүсгэн байгуулагч буюу төрийн төлөөлөл нь УЗ-ийн гишүүдийн 51-60 хувь нь байх бөгөөд Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.
- 2.4. Удирдах зөвлөл дэх багш, оюутан, төгсөгчдийн төлөөллийг хамт олны хурлаас сонгоно.
- 2.5. Удирдах зөвлөлийн гишүүдийг 3 жилийн хугацаагаар томилох буюу сонгох бөгөөд жил бүр зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг шинэчилж болно.



- 2.6. Удирдах зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг дараах нөхцөлд үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Үүнд:
 - 2.6.1. Өөрийн хүсэлтээр;
 - 2.6.2. Удирдах зөвлөлийн гишүүний төлөөллийн байгууллага нь гишүүнээ эргүүлэн татах тухай шийдвэр ирүүлсэн;
 - 2.6.3. Өвчний улмаас болон бусад хүндэтгэх шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон нөхцөлд;
 - 2.6.4. Ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд;
 - 2.6.5. Хууль, ёс зүйн алдаа гаргасан, их сургуулийн дүрмийг удаа дараа зөрчсөн;
 - 2.6.6. Удирдах зөвлөлөөс өгөгдсөн үүрэг даалгаврыг удаа дараа хүндэтгэх бус шалтгаанаар биелүүлээгүй;
 - 2.6.7. Тухайн жилд хуралдах Удирдах зөвлөлийн хурлын 50%-д хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй болон хурлаас удаа дараа хоцорч хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд;
- 2.7. Удирдах зөвлөлийн дарга, дэд даргыг үүсгэн байгуулагчийн төлөөллөөс санал болгох бөгөөд удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаас ил санал хураалтаар 3 жилийн хугацаатай сонгоно. Удирдах зөвлөлийн дарга, дэд даргыг үүсгэн байгуулагчийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлээгүй, хуулийн заалтанд нийцээгүй шийдвэр гаргасан тохиолдолд бүрэн эрхийн хугацааг дуусахаас өмнө Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналаар өөрчилж болно.
- 2.8. Удирдах зөвлөлийн дэд дарга нь даргын эзгүйд түүний үүргийг түр орлон гүйцэтгэнэ.
- 2.9. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг удирдах зөвлөлийн хурлаас томилно.

Гурав. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1. Удирдах зөвлөл нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого шийдвэрийг үндэс болгож, дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. ШУТИС-ийн дүрэм, Удирдах зөвлөлийн дүрэм, дэгийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 3.1.2. ШУТИС-ийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэлэлцэж батлах;

- 
- 3.1.3. Хөрөнгө оруулалт, жилийн төсөв хуваарилалтыг баталж, зарцуулалтад хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив авах журам тогтоох;
 - 3.1.4. Их сургуулийн жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор батлах;
 - 3.1.5. Хөгжлийн бодлогод нийцүүлэх, хичээлийн болон санхүүгийн жилийн уялдааг хангах үүднээс удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар их сургуулийн жилийн төсвийн тодотголыг хэлэлцэж, батлах;
 - 3.1.6. Сургалтын төлбөрийн хэмжээ болон дотуур байрны үйлчилгээний төлбөрийг зохих жишгийг баримтлан тогтоох;
 - 3.1.7. Ректорын саналыг үндэслэн сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоох;
 - 3.1.8. Удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг жил бүр үүсгэн байгуулагчид тайлагнах;
 - 3.1.9. Ректорын ажлын гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх, томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавих;
- 3.2. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал бөгөөд гишүүдийн 60 хувиас доошгүй ирцтэй тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. Хэлэлцсэн асуудлаар олонхийн саналаар шийдвэр /тогтоол/ гаргаж, хурлын тэмдэглэл хөтөлнө. Удирдах зөвлөлийн дарга тогтоолд гарын үсэг зурж, сургуулийн тэмдэг дарж баталгаажуулна.
 - 3.3. Удирдах зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулна. Харин ээлжит бус хурлыг үүсгэн байгуулагчийн, удирдах зөвлөлийн даргын, эсвэл гишүүдийн 1/3-ээс доошгүй хувийн саналаар, ректор удирдах зөвлөлд хандан санал гарган хуралдуулж болно. Хурлын товыг Удирдах зөвлөлийн дарга тогтоож, нарийн бичгийн дарга ажлын 3-5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хэлэлцэх баримт бичгийн төслийг гишүүдэд хүргүүлнэ. Мөн гишүүдийн саналаар цахим шуудангаар хүргүүлж болно.
 - 3.4. Удирдах зөвлөлийн хуралд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ректор, проректор, газар, албадын дарга, ерөнхий болон ахлах нягтлан бодогч, багш, оюутан, төгсөгчдийн төлөөлөгчийг оролцуулан санал, хүсэлт, тайлбарыг сонсож болно.
 - 3.5. Хуралд хүндэтгэх шалтгаанаар оролцох боломжгүй гишүүн хэлэлцэж шийдвэрлэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр буюу цахим шуудангаар өгч болох бөгөөд энэ тохиолдолд хуралд оролцсонд тооцно.
 - 3.6. Удирдах зөвлөл өөрийн үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж болох бөгөөд түүнийг удирдах зөвлөлийн гишүүн ахална.

- 3.7. Удирдах зөвлөлийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.7.1. Удирдах зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах даргалах;
 - 3.7.2. Удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг даалгавар өгч, ажил үүргийн хуваарь гарган хариуцуулах, биелэлтийг хангуулах;
 - 3.7.3. Удирдах зөвлөлөөс томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиглэлийг тогтоох, төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;
 - 3.7.4. Үүсгэн байгуулагч болон их сургуулийн Ректортой тохиролцсоны дагуу Удирдах зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг тогтоох, хурлаас гарсан шийдвэрийг батламжлах;
 - 3.7.5. Ректорын болон их сургуулийн үйл ажиллагаанд чиглэл өгөх;
 - 3.7.6. Их сургуулийн хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх;
 - 3.7.7. Удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаа, оролцооны талаарх үнэлэлт дүгнэлтийг тухайн төлөөллөө сонгосон байгууллагад нь мэдэгдэх;
 - 3.7.8. Үүсгэн байгуулагч болон Удирдах зөвлөлийн гишүүдийн төлөөллийн байгууллагуудын хооронд үүссэн асуудлыг зохицуулах, зөвшилцөх ажлыг зохион байгуулах;
 - 3.7.9. Үүсгэн байгуулагчийн бодлого, шийдвэрийг тайлбарлах, сурталчлах ажлыг зохион байгуулах;
- 3.8. Удирдах зөвлөлийн гишүүн нь энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн, ШУТИС-ийг хөгжүүлэхийн төлөө хүч хөдөлмөр, цаг заваа зарцуулах хүсэлтэй, ашиг сонирхлын зөрчилгүй, асуудлыг хариуцан ажиллах чадвартай байна.
- 3.9. Удирдах зөвлөлийн гишүүн дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
 - 3.9.1. Удирдах зөвлөлийн хуралдаанд таслахгүй, эхлэх цагаас хоцрохгүй, хурлын дэгийг баримтлан оролцох,
 - 3.9.2. Удирдах зөвлөлийн шийдвэр, болон дарга, дэд даргын өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;
 - 3.9.3. Их сургуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл гаргуулах, боловсруулан гаргаж буй аливаа баримт бичиг, төсөл, төлөвлөгөө, тайлантай танилцаж саналаа тусгуулах;
 - 3.9.4. Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох хүмүүст шаардлага тавих, тайлбар гаргуулах, санал санаачлага гаргаж хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх;

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралт

- 3.9.5. Их сургуулийн нэр хүндийг өсгөх, санхүүжилтийн эрх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд идэвхи санаачлагатай оролцох, их сургуулийг хөгжүүлэх талаар удирдах зөвлөлөөс гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 3.9.6. Хариуцсан ажил, үүрэг, даалгаврыг чанартай биелүүлж, зөвлөлийн хурал, даргад танилцуулах;

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. Удирдах зөвлөл нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд зөвлөлийн тогтоол, хурлын шийдвэр, тэмдэглэл гаргах хэвлэмэл хуудастай байна. Удирдах зөвлөлийн албан бичигт их сургуулийн албан тамгыг хэрэглэнэ.
- 4.2. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэрэг, хурлыг зохион байгуулах, шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг их сургуулийн тухайн жилийн төсөвт тусган зарцуулна.
- 4.3. Удирдах зөвлөл нь үйл ажиллагааны явц, үр дүнг үүсгэн байгуулагчийн өмнө тайлагнах ба хэлэлцэх асуудлын талаар үүсгэн байгуулагчтай зөвшилцөж, холбогдох мэдээлэлээр ханган ажиллана.
- 4.4. Үүсгэн байгуулагч болон Удирдах зөвлөлийн гишүүний төлөөллийн байгууллага нь Удирдах зөвлөл дэх өөрийн төлөөллийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай бол энэ дүрмийн 2.6, 2.7-д заасны дагуу арга хэмжээ авна.